



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/39

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Байгууллагын дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.4, 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын эрүүл мэндийг дэмжин, идэвхтэй хөдөлгөөний үйл ажиллагаанд жигд оролцох боломж бүрдүүлэх, спортоор хичээллэх идэвх санаачилга, соёлыг төлөвшүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлж, эерэг хандлагатай, нийтэч хамт олныг бий болгох зорилгоор зохион байгуулах биеийн тамир, спортын арга хэмжээнд зориулан 2,000,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Биеийн тамир, спортын арга хэмжээнд зарцуулах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Бараа, ажил үйлчилгээний зардал болон бусад боломжит зардлаас тооцож гаргахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Энхмандал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Б.САНДАГСҮРЭН

Засаг даргын Тамгын газрын даргын  
2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн  
А/39 дүгээр тушаалын хавсралт



АЙМГИЙН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН  
ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ “СПОРТЫН ТЭМЦЭЭН”-ИЙ ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Эзлүүлэх байр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөл	Бүх байрт	12	5,000	60,000
2	Гар бөмбөг, олс таталтын мөнгөн шагнал	Тэргүүн байр	2	200,000	400,000
		Дэд байр	2	150,000	300,000
		Гутгаар байр	2	100,000	200,000
3	Ширээний теннис, дардасны мөнгөн шагнал	Тэргүүн байр	2	60,000	120,000
		Дэд байр	2	50,000	100,000
		Гутгаар байр	2	40,000	80,000
4	Шүүгчийн зардал	-	2	100,000	200,000
5	Ус	-	100	1,400	140,000
6	Багийн нийлбэр цомын шагнал	-	1	400,000	400,000
Нийт					2,000,000

-oOo-